



ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/Т/Ч

Улаанбаатар хот

Чанарын менежментийн тогтолцооны
хамрах хүрээ, бодлогыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/54 дүгээр тушаал, Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж, тасралтгүй сайжруулалт хийх зорилгоор Чанарын менежментийн тогтолцооны "Хамрах хүрээ"-г нэгдүгээр, "Бодлого"-ыг хоёрдугаар, "Зорилго"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Чанарын менежментийн тогтолцоог газрын үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг Нэгжийн дарга нар, нийт албан хаагчдад, Чанарын менежментийн тогтолцооны явц, хэрэгжилт, үр дүнгийн талаар тухай бүр мэдээлж, цаашид тасралтгүй хэрэгжүүлж ажиллахыг Чанарын баг (Б.Дуламсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Д.Дашцэцэг)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ТӨГСДЭЛГЭР

Газрын даргын 2024 оны 10 дүгээр сарын 21-ний өдрийн АТ/14 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж хэрэгжүүлэх бөгөөд Менежментийн тогтолцооны хамрах хүрээ нь Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон бусад хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах, Архитектур төлөвлөлтийн даалгавар олгох, загвар зураг батлах, инженерийн дэд бүтцийн төлөвлөлт хийх, барилгын ажлын зөвшөөрөл олгох, хотын стандартыг батлуулах, мөрдүүлэх, дэд төв дагуул хотыг хөгжүүлэх, хот байгуулалтын мэдээллийн санг эрхлэх, барилгын паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах асуудлыг авч үзнэ.

НЭГ.ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

1.1 Үйл явцууд

Байгууллага нь дараах үндсэн, удирдлагын болон дэмжих үйл явцтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Чанарын менежментийн тогтолцоо нь эдгээр бүхий л үйл явцуудад хамаарна.

Зураг 1. Байгууллагын үйл явцын тогтолцооны зураглал



1.2 Үйлчилгээ

Байгууллага нь дараах үндсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд тасралтгүй, шуурхай, чанартай үзүүлэх бөгөөд Чанарын менежментийн тогтолцоо нь дараах бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд хамаарна.

Хүснэгт №01 Хамрах хүрээнд багтаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ

№	Үндсэн хүсэлт	Дэд хүсэлт
1.1	Барилга, байгууламж барих /АТД/ хүсэлт	Барилгажсан хэсэгт архитектур төлөвлөлтийн даалгавар хүсэх
1.2		Гэр хорооллын бүсэд архитектур төлөвлөлтийн даалгавар хүсэх
1.3		Тусгай хамгаалалттай газарт архитектур төлөвлөлтийн даалгавар хүсэх
1.4		Нийтийн эдэлбэр газрыг иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөөр тохижуулах, ашиглах, хамгаалах
1.5		Инженерийн дэд бүтэц төлөвлөх, даалгавар хүсэх
1.6		Авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар хүсэх
1.7		Нийслэлийн нутаг дэвгэрт иргэн хуулийн этгээдийн санаачилгаар авто зогсоол төлөвлөх
1.8		Ашиглалтын шаардлага хангахгүй барилгад даалгавар олгох
1.9		Архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлт
2.1	Загвар зураг батлуулах хүсэлт	Барилгажилтын төслийг (ГХДТ/АШХНОСБ) хянаж, батлуулах
2.2		Барилгын загвар /эскиз/ зургийг хянаж, батлуулах
2.3		Авто зам, замын байгууламжийн загвар зургийг хянаж, батлуулах
2.4		Гадна тохижилтын ажлын загвар зургийг хянаж, батлуулах
3.1	Барилгын ажлын зөвшөөрөл гэрчилгээний хүсэлт	Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ шинээр олгох
3.2		Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа сунгуулах
3.3		Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах
3.4		Инженерийн шугам сүлжээний зөвшөөрлийн гэрчилгээ авах
3.5		Цахилгааны ажлын зөвшөөрлийн гэрчилгээ авах
3.6		Барилга байгууламжийг буулгах ажлын зөвшөөрлийн гэрчилгээ авах
4.1		Инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын зураг төсөл, төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх

4.2	Шугам сүлжээний ажлын зураг зөвшилцөх хүсэлт	Мэдээлэл холбооны шугам сүлжээний ажлын зураг төсөл, төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх
4.3		Дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх
4.4		Цахилгаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх
4.5		Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төсөл, төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх
4.6		Хийн хангамж, сэргээгдэх эрчим хүчний шугам сүлжээний ажлын зураг төсөл, төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх
5.1	Барилгад хаяг дугаар олгох, мэдээллийн санд бүртгүүлэх хүсэлт	Шинээр ашиглалтад орж байгаа барилгад хаяг дугаар шинээр авах
5.2		Хуучин барилгад хаяг дугаар олгох
5.3		Зуслан, амины болон гэр орон сууцны барилгад хаяг дугаар олгох
5.4		Хуучин хаягтай барилгад дахин тодорхойлолт олгох
5.5		Улсын комиссын акт баталгаажсан барилгад дахин тодорхойлолт олгох
6.1	Зурган мэдээлэл авах хүсэлт	Инженерийн шугам сүлжээний зурган мэдээлэл авах
6.2		Хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зурган мэдээлэл авах
7.1	Тэг тэнхлэгийн актыг мэдээллийн санд бүртгэх	Тэг тэнхлэгийн актыг мэдээллийн санд бүртгэх /Барилга байгууламж/
7.2		Тэг тэнхлэгийн актыг мэдээллийн санд бүртгэх /Инженерийн шугам сүлжээ/
8.1	Байр зүйн зургийг мэдээллийн санд бүртгэх	Гүйцэтгэлийн байр зүйн зургийг мэдээллийн санд бүртгүүлэх
9	Архивын лавлагаа авах хүсэлт	

1.3 Зохион байгуулалтын бүтэц, нэгжүүд

Хамрах хүрээнд байгууллага нь дараах бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд чанарын менежментийн тогтолцоо нь эдгээр нэгжүүдэд хамаарна.

Хүснэгт №02 Хамрах хүрээнд багтаж буй бүтэц, зохион байгуулалт

д/д	Алба нэгжүүд	Үйл явцийн оролцоо
1	Захиргаа, удирдлагын хэлтэс	Удирдах
2	Ерөнхий Архитекторын ажлын алба	Үндсэн

3	Барилга хот байгуулалтын хэлтэс	Үндсэн
4	Хот төлөвлөлтийн хэлтэс	Үндсэн
5	Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс	Дэмжих
6	Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс	Үндсэн
7	Барилга байгууламжийн чанар, стандартын хэлтэс	Үндсэн
8	Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтэс	Үндсэн
9	Хотын стандарт, хөгжлийн хэлтэс	Үндсэн
10	Хот байгуулалтын хяналтын хэлтэс	Үндсэн
11	Хуулийн хэлтэс	Дэмжих

Зураг 02 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



НИЙТ ОРОН ТОО 128

Газрын даргын 2024 оны 10 дүгээр сарын 24-ний өдрийн 114 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд дэвшилтэт технологид суурилсан хот байгуулалт, төлөвлөлт, хотын стандартыг бий болгож, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлэн, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг байнга дээшлүүлж, албан хаагчдыг эрүүл, аюулгүй ажлын байраар хангаж чанарын менежментийн тогтолцооны байнгын сайжруулалтыг хэвшүүлж ажиллана.

__oOo__

Газрын даргын 2024 оны 10 дүгээр сарын 24-ний өдрийн А/74 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЗОРИЛГО,
ТҮҮНД ХҮРЭХЭД ЧИГЛЭСЭН ТӨЛӨВЛӨЛТ**

Чанарын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд жил бүр хэмжигдэхүйц чанарын зорилгуудыг тодорхойлж, мөрдөж ажиллана.

№	Зорилгын утга	Хэмжих нэгж	Суурь түвшин /2023он/	Хүрэх түвшин /2024 он/
1	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд Чанарын удирдлагын менежментийн тогтолцоо /ISO9001:2015/ олон улсын стандартыг нэвтрүүлж гэрчилгээ авах	тоо	-	1
2	Албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрөмжийг шинэчлэх	тоо	-	50
3	Ebarilga цахимаар системээр бүх үйлчилгээний хүсэлтийг хүлээн авах /шийдвэрлэлтийг үйл явц ил тод болгох/	тоо	36	37
4	Өргөдөл гомдол шийдвэрлэх хугацааг 1 хоногоор багасгах	хоног	9 хоног 8 цаг	9 хоног

Хот байгуулалт, хотын стандартын газрын Чанарын зорилгод үндэслэн хэлтэс, нэгж бүр Чанарын дэд зорилтыг шинэчлэн тодорхойлох бөгөөд жилийн эцэст зорилгын биелэлтийг Чанарын баг дүгнэнэ.

Газрын бодлого, зорилгыг нийт албан хаагчдад мэдээлсэн байна. Хэлтэс, нэгжийн Чанарын зорилгыг хангахад албан хаагч бүр өөрийн оролцоо, хичээл зүтгэлийг гаргана.

Чанарын зорилгод хүрэх төлөвлөлтийг нэгж бүр хийж, үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэгтгэж тусгана.